



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/56

Мандагговь

“Люкс товер” ХХК-тай гэрээ байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/27 тоот захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн “Зураг төсөв боловсруулах” ажлын зардлаас “Аймгийн Засаг даргын тамгын газрын гадна пасад, дээврийн зураг, төсөв боловсруулах” ажлыг 12,230,000 (арван хоёр сая хоёр зуун гучин мянга), “Д. Чагдаржавын талбайн тохижилтын зураг, төсөв боловсруулах” ажлыг 6,970,000 (зургаан сая есөн зуун далан мянга) төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн үнийн саналаар “Люкс товер” ХХК-тай нийт 19,200,000 (арван есөн сая хоёр зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан зургийн даалгаврын дагуу уг зураг төсөв боловсруулах ажлуудыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Люкс товер” ХХК-ийн захирал (О. Алтанбагана)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтийн хэлтсийн дарга (Н. Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э. Чагнаадорж), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г. Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л. ДОРЖБАТ

4822150120